

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 8

Хуралдаан 2013 оны гуравдугаар сарын 21-ний өдрийн 14 цаг 03 минутад эхэлж, 16 цаг 14 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 11 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Увс аймагт зохион байгуулсан Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, бүртгэгдсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан өрсөлдсөн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 56 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 03 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Увс аймагт зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <ol style="list-style-type: none">1. Увс аймагт 2013 оны 03 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нийт 74 иргэн, үүнээс 17 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д, 57 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэснийг 1, 2 дугаар хавсралтаар тус тус батлах.2. Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн

		<p>жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-д тус тус бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 7 иргэнийг, "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт"-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 17 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 3, 4 дүгээр хавсралтаар тус тус батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын хоёрдугаар зүйлд заасан нэр бүхий 24 иргэнийг "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулахыг Увс аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Барилга, хот байгуулалтын яамны зарим газар (4)-ын даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"> -Төрийн захиргааны удирдлагын газрын дарга -Барилга, барилгын материалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга -Орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга -Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах 	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "а", "б"-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд Цэдэнсамбын Доржпаламыг, Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын</p>

	<p>газрын дарга</p>	<p>бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Банзрагчийн Цэдэнсамбыг, Барилга, хот байгуулалтын яамны Орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Раднаабазарын Эрдэнэцэцэгийг, Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Цогтын Баярбатыг тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Эрдэнэбүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
<p>3</p>	<p>Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны зарим газар (3)-ын даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай -Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга -Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга -Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Цэрэннадмидын Ринчинсэнгээг, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Даваагийн Тунгалагийг, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд Ухабайн Саулег тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Золжаргалд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

4	<p>УИХ-ын Тамгын газрын хэлтэс (4)-ийн даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"> -Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн дарга -Хяналт үнэлгээний хэлтсийн дарга -Мэдээллийн технологийн хэлтсийн дарга -Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн дарга 	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.4, 22 дугаар зүйлийн 22.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”, “б”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд Жадамбын Дашдоржийг, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт, үнэлгээний хэлтсийн даргын албан тушаалд Лувсанцэрэнгийн Энхтуяаг, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээллийн технологийн хэлтсийн даргын албан тушаалд Жаргалсайханы Элбэгзаяаг, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа, нийтлэг үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд Начингийн Ширэндэвийг тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
---	---	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

